

## ТАНИЛЦУУЛГА

### Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийн тухай

2018.10.10

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 11 дүгээр тогтоолын Хавсралтын 132-д “Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх” гэж, 2016 оны “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 45 дугаар тогтоолын хавсралтын 5.3.10-д “Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

2013 онд батлагдсан, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулиар төлбөрийн чадваргүй яллагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж байна.

Уг хууль батлагдсанаас хойш нийт 3 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр 10 орчим зүйл, заалтад өөрчлөлт орсон. Ийнхүү нэмэлт, өөрчлөлт орсон хэдий ч хуулийн зүйл, заалтын уялдаа холбоо муу, нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, зарим шаардлагатай зохицуулалт тусгагдаагүй байна.

Хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнээс хойш Хууль зүйн туслалцааны төвөөс 2014-2017 онд 29004 иргэнд хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээллийг өгсний сацуу нийт 9948 эрүүгийн хэргийн 10900 холбогдогчид хамаарах хэргийг хүлээн авч 6212 хэргийг шүүхээр, 926 хэргийг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлсэн байна. Үүнээс харахад улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн нийт эрүүгийн хэргийн 22.4 орчим хувьд улсын өмгөөлөгч оролцжээ.

Хуулийн хэрэгжилттэй холбогдох судалгаа, олон улсын туршлагаас харахад хууль зүйн туслалцааг зөвхөн эрүүгийн хэргийн яллагдагчаар хязгаарлахгүйгээр хуулийн зохицуулалтад өөрчлөлт оруулах, мөн иргэн, захиргааны зарим хэрэг, маргаанд оролцогч төлбөрийн чадваргүй хүн, зарим зорилтот бүлгийн иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулах бөгөөд хуулийн төсөлд одоо байгаа хууль зүйн туслалцааны тогтолцоог хэвээр үлдээхийн сацуу хуулийн төслийг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагын үүднээс дараахь зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгалаа:

1.Хуульд оновчгүй хэрэглэсэн болон тодорхойлох шаардлагатай нэр томъёог холбогдох хуультай нийцүүлэн тодорхойлж, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны үндсэн зарчим, хууль зүйн туслалцааны төрөл, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах эрх бүхий хүн, төлбөрийн чадваргүй байдлыг хэрхэн тодорхойлохыг нарийвчлан зохицуулна;

2.Улсын өмгөөллийн үйлчилгээг зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагчаар хязгаарлахгүй, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эрүүгийн зарим хэргийн арван найман насанд хүрээгүй хохирогч, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч болон зарим иргэний болон захиргааны хэрэг маргааны оролцогчид болон зорилтот бүлэгт үзүүлэхээр тогтоож, хамрах хүрээг өргөжүүлнэ.

3.Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах шаардлагатай нийгмийн бусад зорилтот бүлэг орхигдогдож байгааг анзаарч хууль зүйн туслалцааг авах эрхтэй хүний хамрах хүрээг тогтооно.

4.Хууль зүйн туслалцааны төрлийг нэмэгдүүлж эрх зүйн сургалт сурталчилгаа хийх зохицуулалтыг тусгана.

5.Хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах үндэслэл, татгалзах шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдол гаргах эрхийг тодорхой болгох, түүнтэй холбоотойгоор хууль зүйн туслалцаа авч байгаа иргэн болон хуулийг хэрэгжүүлэгч байгууллагын хариуцлагыг асуудлыг тусгана.

6.Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлж байгаа хууль зүйн туслалцааны албан болон албан бус тогтолцоог уялдуулах замаар хууль зүйн туслалцааны нэгдсэн тогтолцоо, мэдээллийн санг бий болгоно.

7.Хууль зүйн туслалцаа үзүүлж буй байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, чиг үүргийг нарийвчлан тодорхойлж улсын өмгөөлөгчийн эрх зүйн байдал, ажиллах нөхцөл, баталгаа түүнтэй холбоотой бусад харилцааг тодорхой болгоно.

8.Хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийг бусад орлогын эх үүсвэрээс санхүүжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

9.Хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд бусад байгууллагын оролцоо, хувийн өмгөөлөгчийг оролцуулах журам, санхүүжилтийг тодорхой болгож, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгана.

Хуулийн төсөл батлагдсанаар төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх хууль зүйн туслалцааны тогтолцоо боловсронгуй болж, төлбөрийн чадваргүй байдлаасаа болж хууль зүйн туслалцаа авах эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах зэрэг эрх, эрх чөлөө нь баталгаажиж, иргэний үндсэн эрхийн баталгаа сайжирна гэж үзэж байна.

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**